


МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сэрээтэр	Дугаар	L362
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Өлзийт сум
Төрсөн газар	Өлзийт сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан хадны хийд, Хар ноёны хийд, Далайн хийд	Сүм хийдийн дугаар	ДУӨЗ 049, ДУӨЗ 059, ДУӨЗ 060
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 7-р сарын 22	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Өлзийт сумын Далайн хийд, Цагаан хадны хийд, Хар ноёны хийд

Жужа: За та Цагаан хадны хийдийн тухай ярина уу?

Сэрээтэр: Үгүй ээ, одоо мэдэхгүй. Лам нар нь татагдах нь татагдаад үхэх нь үхээд дууссан.

Жужа: Хэдэн дугантай байсан бэ?

Сэрээтэр: Нэг хоёр юм байсан юм уу.

Жужа: Модон дуган уу, тоосгон дуган уу?

Сэрээтэр: За шавар маягийн тоосгон, улаан тоосгон дуган байсан.

Жужа: Хэдэн лам сууж байсан юм бол?

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэрээтэр: За мэдэхгүй, ёстой мэдэхгүй.

Жужа: Барагцаагаар?

Сэрээтэр: Барагцаагаар нэг 20 орчим лам байсан юм уу.

Жужа: Суварга байсан уу?

Сэрээтэр: Суварга байсан, байсан. Хурд ч байсан. чухам суварга хаана байсныг мартчихаж. Тойроод л лав хурд байсан.

Жужа: Цам байсан уу?

Сэрээтэр: Мэдэхгүй байна.

Жужа: Майдар?

Сэрээтэр: Үгүй байх аа, харин Далайн хийд гэж байсан, тэнд майдар эргэдэг байсан байх. Далайн хийд чинь хөнжил гэдэг нэртэй газар байсан юм.

Жужа: Далайн хийд хэдэн лам, хэдэн дугантай байсан бэ?

Сэрээтэр: Өө олон дуган байсан, за лав л цогчин, дарь эх, манба өөр юу юу ч билээ дээ. Тав зургаан дуган лав байсан, лам нар ч нэлээн олон байсан.

Жужа: Далайн хурал цам гардаг байсан уу?

Сэрээтэр: Үгүй.

Жужа: Далайн хийдийн дуган мод байсан уу, шавар дуган байсан уу?

Сэрээтэр: Шавар дуганууд байсан.

Жужа: Далайн хийдийн тэргүүн лам нь ямар хүн байсан бэ?

Сэрээтэр: Мэдэхгүй ээ, мартчихаж.

Жужа: Цагаан хадны тэргүүн лам?

Сэрээтэр: Хэн билээ, нэг гэсгүй л байсан.

Жужа: Та Хар ноёны хийдийн тухай мэдэх үү?

Сэрээтэр: Өө тэр Угалзын нөөлгийн зүүн ам гэдэг газар байсан юм, жижигхэн хийд. Хоёр дугантай, арваад ламтай.

Жужа: Тэгвэл Эрдэнэ баяны хийдийн тухай?

Сэрээтэр: Хоёр дугантай жижигхэн хийд л байсан юм гэнэ лээ.

Жужа: Лүйжинч зоч лам нар аль хийдүүдэд байсан бэ?

Сэрээтэр: Өө байсан байлгүй. Сайн мэдэхгүй байна, мартчихаж, ер санаанд орохгүй юм.

Жужа: Ганжуур эргэж байсан уу?

Сэрээтэр: Эргэж байсан байх аа. Ганжуур эргэнэ гээд л ном баглаж үүрээд л урд чинь хавчиг бүррэг гээд нэг юм байсан юм, мэдэх үү. Тэрэнд чинь ном баглаж үүрээд л явдаг байсан юм. Тэгээд гороогоо тойроод л явна, нөгөө хийдээ тойроод ном уншаад л. Тэрнийг чинь ганжуур эргэнэ гэдэг юм.

Жужа: Хийдүүд хэдэн онд хаагдсан бэ?

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Сэрээтэр: За одоо тэр чинь хэдэн он гэдэг юм бэ, сая гардаг манай энэ ганц хүүхэн далан настай, энийг гэдсэнд байхад л хаагдсан юм. Тэгэхээр хэдэн он болж байна. / 2007-70=1937 /

Энхбаяр: Та ч одоо хэдэн онд төрсөн хүн бэ?

Сэрээтэр: Би Наян естэй, туулайтай. Тэгэхээр хэдэн он болж байна. Энэ хүн ерэн гуравтай.

Жужа: Тэр хийдүүдэд байсан лам нараас одоо бий юу?

Сэрээтэр: Байхгүй, байхгүй бүгд одоо үхсэн.

Жужа: За таньд баярлалаа.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

3